

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ
НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТАЙЛАН**

2025 оны 02 сарын 17

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Дундговь аймгийн Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх, хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх, зохион байгуулалтыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 -т заасан арга зүйгээр үнэлэн Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн unelgee.gov.mn цахим санд байршуулсан.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн 2 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 -т заасан аргачлалын дагуу хяналт- шинжилгээ, үнэлгээг хийхэд 80 хувьтай байна.

Тухайн жилийн төлөвлөлт болон хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээг жилд 1 удаа хийж, холбогдох төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс Аймгийн Засаг даргын Тамгын газраас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан удирдамжийн дагуу 15 сум, 24 агентлагийн жилийн эцсийн үйл ажиллагааг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд тусган

үнэлгээ хийж, сумдын үнэлгээний дундаж 79,7 хувьтай, агентлагуудын үнэлгээний дундаж 86,8 хувьтай дүгнэгдэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөмж өгч, зөвлөн туслах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл,
нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан онцлох
ажил

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх хүрээнд

Дундговь аймгийн хэмжээнд 2021-2024 онд “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг санаачлан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжүүлээд байна.

“Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд аймаг орон нутгийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай өндөр чадамж бүхий боловсон хүчнийг салбар бүрд тасралтгүй бэлтгэж 2020 оны байдлаар 64.9 хувьтай байсан боловсон хүчний хангалтыг 2024 онд 85 хувьд хүргэх зорилт тавин 90,2 хувьд хүргэсэн байна.



Албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр Засгийн газар болон төрийн байгууллагаас зохион байгуулсан 325 удаагийн сургалтад 4182 албан хаагчийг хамруулсан байна. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 хэлтэс агентлаг, 15 сумын төсвийн 134 байгууллагын 2564 төрийн албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх 308 удаагийн ажлын байрны сургалтад хамруулсан байна.



Аймгийн хэмжээнд “ЗАСАГЛАЛЫН МЕНЕЖМЕНТ-НУТГИЙН ХӨГЖИЛ” удирдах ажилтны сургалт зөвлөгөөний арга хэмжээ зохион байгуулж, 15 сум, 24 агентлагийн 452 албан амжилттай оролцож мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.



Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайруулах зорилтын хүрээнд 5 сумын ЗДТГ, Тусгай чиг үүргийн 6 байгууллагад нэн шаардлагатай техник хэрэгслийн хангалт хийж 60,2 сая төгрөгийг зарцуулаад байна.


Төрийн албанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа 47 төрийн албан хаагчид байр орон сууц болон монгол гэрийн 435,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлээд байна.



Гадаад орны сайн туршлагыг орон нутагт нэвтрүүлэх, албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх санал, санаачилгыг дэмжин гадаад улс орнуудтай туршлага судлах ажлыг зохион байгуулж, 2024 онд 9 гадаадын улс орнуудад салбар салбарын 98 төрийн албан хаагчийг туршлага судлах болон мэргэжил дээшлүүлж мэргэшүүлэх сургалтад хамруулж, орон нутгийн төсөв “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрөөс 133.5 сая төгрөгийг зарцууллаа.

Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр МУБИС, ШУТИС, ХААИС, АУИС, Глобал удирдагч их сургуулиудад суралцаж байгаа 35 оюутантай гэрээ байгуулж 67.7 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгт хамруулсан байна.

Аймгийн сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багш нарын баг, сургуулийн удирдах ажилтан, сурагчдын урамшууллын тогтолцоог бий болгох арга хэмжээний хүрээнд нийт 393 багш сурган хүмүүжүүлэгч, 781 сурагчийн хөгжлийг дэмжин ажиллаж 510,1 сая төгрөг зарцуулсан байна.




Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах


Дундговь аймгийн хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа шинэ санал санаачилга, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж 2024 оны аймгийн шилдгээр шалгарсан шилдэг менежер, төрийн албан хаагч, сурагч, ААН байгууллага, Төрийн бус байгууллага, нийгмийн хариуцлагатай өрхүүдэд шагнал гардуулж, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр 486.5 сая төгрөгийг зарцуулсан байна.




Төрийн албан хаагчдын цалин хөлс, шагнал урамшууллыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу бүрэн олгож 2024 онд орон нутгийн төсөвт байгууллагын нийт 41.8 тэр бум төгрөгийн санхүүжилтээс 36.5 хувийг төрийн албан хаагчдын цалин, урамшуулалд зарцуулагдсан байна.




Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын албан хаагчдад хоол унааны хөнгөлөлтөд 179.5 сая төгрөгийг зарцуулсан байна.



Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангаж буй байдалд сэтгэл ханамжийн судалгаа авахад 84,1 хувьтай байгаа нь өмнөх оноос 1,3 хувиар өссөн байна. Сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн албан хаагчдад 60,2 сая төгрөгөөр шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан байна.



Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт 2687 төрийн албан хаагчийг хамруулж нийт төрийн албан хаагчийн 93,2 хувийг бүрэн хамруулсан байна.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 зорилт 7 арга хэмжээ, 26 шалгуурын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, 80 хувийн гүйцэтгэлтэйгээр үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	Хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх		
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	70


3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	50
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах		
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	90
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	50
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	100
	Дүн	80

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 206 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу Дундговь аймгийн Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн 2020-2024 оны үзүүлэлтийг харьцуулан графикаар харууллаа.

2020-2024 оны үр дүнгийн үзүүлэлт



Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад зарцуулсан хөрөнгийн хэмжээг сүүлийн 3 жилээр тооцож харуулав.



Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт төрийн албан хаагчдын 3 хувийг эзэлж байгаа нь зорьсон түвшиндээ хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт 93,2 хувь нь хамрагдсан хэдий ч онцлог томоохон арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, эрүүл мэндэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан төсвийн 0,002 хувийг эзэлж байгаа нь эрүүл мэндэд чиглэсэн арга хэмжээг үр дүнд хүрэхээр зорьж төлөвлөн, хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

ТАВ: ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ

1. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх хүрээнд суурь судалгааг нарийвчлан гаргаж, үр дүнд суурилсан төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх
2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр аян, арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцох

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС